

Худалдан авах ажиллагааны гэрээний гүйцэтгэлд үнэлгээ хийх ажлын тайлан

Ажлын зорилго :

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй худалдан авах ажиллагааны хүрээнд зарлагдаж, зохион байгуулагдаж, шалгарсан гүйцэтгэгч компани, иргэн, иргэдийн бүлгийн гэрээний үүргийн биелэлт ямар байгаа, гүйцэтгэсэн ажил , нийлүүлсэн барааны тоо хэмжээ, чанарын байдал нь гэрээний шаардлагад нийцсэн эсэх, тухайн бараа ажил үйлчилгээг хэрэгжүүлэх хяналт тавих процесст иргэд олон нийтийн оролцоо ямар түвшинд хангагдсан, шууд үр шим хүртэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч гэрээний гүйцэтгэлд үнэлгээ хийж захиалагчид зөвлөмж хүргүүлэх.

Ажлын хугацаа : 2013 оны 9 сарын 11-18

Байршил : Увс аймгийн Улаангом, Тариалан, Өмнөговь сум

Зөвлөх : ХЗӨЧДТ ТББ тэргүүн Р.Итгэл, ХААА-ны мэргэжилтэн Х.Алтанцэцэг

1. Тариалан сум

1.1 Тариалан сумын төвийн нийтийн хог хаягдлыг цэвэрлэж, отвальдах, газар торлон харуул хамгаалалттай болгох төсөл.

Энэхүү төсөл нь 24,7 сая төгрөгний төсөвтэй ажил. Уг ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаагаар зохион байгуулсан гэж байгаа боловч харьцуулалтын аргаар тендер зохион байгуулсан. Уг тендерт “Тарвагатай хайрхан” хоршоо, “БСДА” ХХК оролцсон байна. Үнэлгээний хорооны эхний хурлаар “Тарвагатай хайрхан” хоршоог шалгаруулсан боловч “БСДА” ХХК гомдол гаргасны дагуу уг гомдол үндэслэлтэй гэж үзэн дахин хуралдаж “БСДА” ХХК компанийг шалгаруулжээ.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
91,8 % биелэлттэй хүлээлгэн өгсөн. Акт нь байгаа гэсэн.	Нийт 36 га газрын хогийг цэвэрлэж, 5 га газар тор татан хамгаалат хийсэн.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзэхэд мөн сайн гэдэг нь харагдсан.	Явцын дунд хяналт үнэлгээг хийж байсан. Иргэдийн зүгээс мөн хяналтанд оролцсон гэсэн.	Нийт 26 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -18 Дунд - 3 Муу - 4

Хавсралт : Үнэлгээний хорооны хурлын протокол, гэрээний маягт, өргөдөл зэрэг 5 хуудас материал



1.2 Тариалан сумын халуун усны барилга угсралтын ажил

Энэхүү төсөл нь 99,8 сая төгрөгний төсөвтэй ажил. Уг ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан. Уг тендерт “Ундрах бүтээмж” ХХК, “Амарсанаа” ХХК, “Эрдэнэ-Дэглий” ХХК оролцсон байна. Үнэлгээний хорооны эхний хурлаар уг тендерийг хүчингүй болгон дахин зарласан. Дахин зарласан тендерт “Ундрах бүтээмж” ХХК шалгарсан байна.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
80 % биелэлттэй ажил үргэлжилж байна.	Барилгын ажил дуусах шатандаа, дотор засал, сантехникийн холболтууд хийгдэж байна.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзэхэд боломжийн хэмжээнд харагдсан. Харин Тог цахилгаан, усны асуудлаа яаж шийдэх нь мэдэгдэхгүй байна.	Явцын дунд хяналт үнэлгээг хийж байсан. Иргэдийн зүгээс мөн хяналтанд оролцсон гэсэн.	Нийт 26 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -16 Дунд - 1 Муу - 7

Хавсралт : Үнэлгээний хорооны хурлын протокол, гэрээний маягт, өргөдөл зэрэг 8 хуудас материал





1.3 Тариалан сумын Цэвэр орчин бидний ирээдүй төсөл

Энэхүү төсөл нь 1,9 сая төгрөгний төсөвтэй ажил. Уг ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтанд Цээлэйсүрэн ахлагчтай иргэдийн бүлгийн ирүүлсэн материалыг авч хэлэлцэн дэмжсэн байна. Уг бүлэг нь 25 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Хөдөлмөрийн хэлтэстэй гэрээ байгуулан 2500000 төгрөгний ажилчдын цалинг гаргуулахаар болж гэрээ байгуулсан байна.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
90 % биелэлттэй дууссан. Техникээр хийх ажил үлдсэн. Том чулуу зөөх	Сумын төвийн эхэн, доод хэсгээр байрлах хог чулууг ачиж цэвэрлэсэн.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзэхэд боломжийн хэмжээнд харагдсан.	Явцын дунд хяналт үнэлгээг хийсэн тайлан нь байсан. Иргэдийн зүгээс уг ажилд идэвхитэй оролцсон .	Нийт 26 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -13 Дунд - 3 Муу - 5


Хавсралт : Үнэлгээний хорооны хурлын протокол, гэрээний маягт зэрэг 6 хуудас материал



1.4 Тариалан сумын мал угаалгын ванн шинээр барих сэргээн засварлах төсөл

Энэхүү төсөл нь 10 сая төгрөгний төсөвтэй ажил. Уг ажлыг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтанд Лхагвасүрэн ахлагчтай иргэдийн бүлгийн ирүүлсэн материалыг авч хэлэлцэн дэмжсэн байна. Уг бүлэг нь 4 хүний бүрэлдэхүүнтэй

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
70 % биелэлттэй байгаа. Санхүүжилт дутуу	“Тарвагатай” багийн нутагт байрлах “Гурван булагт” шинээр сал угаалгын ванн барих, “Мянган” багийн нутагт байрлах “Шар хургадад” хуучин мал угаалгын ванн засварласан.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзэж чадаагүй.	Явцын дунд хяналт үнэлгээг хийсэн гэсэн. Иргэдийн зүгээс уг ажилд идэвхитэй оролцсон .	Нийт 26 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -5 Дунд - 2 Сумын төвийн хүмүүс ихэнх нь мэдэхгүй байлаа.



Хавсралт : Үнэлгээний хорооны хурлын протокол, гэрээний маягт зэрэг 6 хуудас материал

Дүгнэлт

Судалгааны дүгнэлээс харахад

1. Та сумын 2013 оны орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын төлөвлөлтөнд саналаа өгч оролцсон уу гэсэн асуултанд
Тийм -17 Үгүй - 9
2. Хэрэв та төлөвлөлтөнд саналаа өгч оролцсон бол таны санал төлөвлөгөөнд тусгагдаж чадсаны гэсэн асуултанд
Тийм – 16 Үгүй - 8
3. Орон нутгийн хөгжлийн сангаар танай суманд ямар ямар ажлууд хийгдэхээр төлөвлөснөөс одоогоор ямар ямар ажлууд хийгдсэн талаар та мэдэж байна уу гэсэн асуултанд
Тийм – 15 Үгүй – 9
4. Танай суманд тендер зохион байгуулалт хэр зэрэг шударга явагддаг вэ гэсэн асуултанд
Шударга явагддаг – 9
Шударга бус явагддаг – 3
Мэдэхгүй – 14
5. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын төлөвлөлт, шалгаруулалт, хэрэгжилтэнд хяналт тавих эрхтэй гэдгээ та мэдэхүү гэсэн асуултанд
Тийм – 2 Үгүй -3

Судалгаанаас үзэхэд уг суманд хийгдэж байгаа ажлын гүйцэтгэл сайн, иргэд идэвхитэй оролцдог боловч хийж буй ажлуудыг олон нийтэд таниулах тал дээр хангалтгүй байна.

Ололттой тал :

- Тариалан суманд олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь сайшаалтай байна.
- Харин уг ажиллагааны нарийн горимыг нь мэдэхгүйгээс эхнээс нь дуусах хүртэл дутуу зохион байгуулсан байна. Гэвч анхлан зохион байгуулж байгаа гэхэд ажлын гүйцэтгэл сайтай иргэдийн зүгээс сэтгэгдэл өндөр байна.
- Бүлгийн гишүүдийн цалин хөлсийг хөдөлмөрийн хэлтэстэй гэрээ байгуулан олгосон нь сайн болсон

Хүндрэл бэрхшээл :

- Үнэлгээний хороонд орж ажиллаж байгаа хүмүүсийн мэдлэг маш муу
- Иргэдийн хувьд худалдан авах ажиллагааны талаар ойлголт хангалтгүй
- Тендерт оролцогч компани, иргэд нь хуулиа мэдэхгүйгээс болж маргаан гардаг.
- Санхүүжилт нь хугацаандаа ирдэггүй

Анхаарах зүйлс :

- Худалдан авах ажиллагааны талаарх сургалт суртачилгааг олон нийтэд хийж зөв ойлголт өгөх.
- Үнэлгээний хорооны гишүүдийн мэдлэгийг нэмэгдүүлэх.
- Хийсэн ажил, шалгарсан тендерүүдийн явцын талаар иргэдэд мэдээлэл өгч байх.

- Тухайн худалдан авах ажиллагааны талаарх материалууд дутуу байгаа нь бичиг баримт бүрдүүлэлт, архивлах тал дээр анхаарах хэрэгтэйг харуулж байна.
- Байгуулсан гэрээнүүд нь гэрээний наад захын шаардлага хангахгүй байна. Үүнд талуудын үүрэг хариуцлага тодорхой бус, санхүүжилтийн хуваарь байхгүй, гэрээ зөрчсөн үед авах арга хэмжээний талаар тусгаагүй байна. Иймд гэрээ байгуулахдаа эдгээр зүйл заалтыг нарийн тусгаж ажиллах хэрэгтэй.

2 Өмнөговь сум

2.1 Орон нутгийн зам засах.

Энэхүү төсөл нь 2 сая төгрөгний төсөвтэй ажил. Уг ажлыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан. Ажлыг 2-р багийн иргэн сумын хурлын төлөөлөгч Т.Батхүү гэрээлэн гүйцэтгэсэн. 2-р багийн нутагт Яргайтын үзүүр, Довтын хөндийн замыг нутгийн иргэдийн оролцоотой засаж янзалсан байна.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
100 % биелэлттэй хүлээлгэн өгсөн. Акт нь байхгүй байлаа.	40-60 иргэнийг 2 удаагийн ажлаар хийж дуусгасан.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзэж чадаагүй. Хүлээн авсан үеийн болон өмнөх үеийн зурагууд нь байгаа гэсэн боловч авч чадсангүй.	Явцын дунд хяналт үнэлгээг хийж байсан. Багийн иргэд өөрсдөө хийсэн учир хяналт сайн. Хурлын дарга, орлогч дарга нар өөрсдөө очиж хяналт тавьсан	Нийт 23 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -6 Дунд - 2

Хавсралт : Ажил гүйцэтгэх гэрээ 1 хуудас материал

2.2 Сумын төвийн хог балгас цэвэрлэх.

Энэхүү төсөл нь 6,3 сая төгрөгний төсөвтэй ажил. Уг ажлыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан. Ажлыг “БСДА” ХХК гэрээлэн гүйцэтгэсэн байна. Сумын төвийн эзэнгүй балгасыг нурааж цэвэрлэсэн.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
100 % биелэлттэй хүлээлгэн өгсөн. Акт нь байхгүй байлаа.	Сумын төвийн эзэнгүй болсон балгасуудыг нурааж цэвэрлэсэн.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзсэн. Одоо уг газар дээр иргэд шинээр газар аван хашаа барьж босгосон байна.	Явцын дунд хяналт үнэлгээг хийж байсан. Хурлын дарга Эрдэнэ өөрийн биеэр хяналт тавьсан	Нийт 23 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -16 Дунд - 4

Хавсралт : Ажил гүйцэтгэх гэрээ 1 хуудас материал



2.3 Сургууль, Цэцэрлэг, Эмнэлэгийн орчны хог цэвэрлэх.

Энэхүү төсөл нь 2,7 сая төгрөгний төсөвтэй ажил. Уг ажлыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан. Ажлыг 5-р багийн иргэн Г.Хүрэлбаатар гэрээлэн гүйцэтгэсэн байна. Сургууль, Цэцэрлэг, Эмнэлэгийн гаднах овоорсон үнс нурмыг зайлуулсан.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
100 % биелэлттэй хүлээлгэн өгсөн. Акт нь байхгүй байлаа.	Сургууль, Цэцэрлэг, Эмнэлэгийн гаднах овоорсон үнс нурмыг зайлуулсан.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзсэн.	Явцын дунд хяналт үнэлгээг хийж байсан. Хурлын дарга Эрдэнэ өөрийн биеэр хяналт тавьсан	Нийт 23 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -16 Дунд - 4

Хавсралт : Ажил гүйцэтгэх гэрээ 3 хуудас материал



2.4 Сумын өв соёлыг судлаж баримтжуулах.

Энэхүү төсөл нь 1 сая төгрөгний төсөвтэй ажил. Уг ажлыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан. Ажлыг 5-р багийн иргэн С.Өлзий гэрээлэн гүйцэтгэсэн байна. Сумын хэмжээн дахь түүх соёлын дурсгалт газар, байгалийн өвөрмөц тогтоц, иргэдийн гар дээр байгаа эд өлгийн зүйлсийг баримтжуулах ажил хийсэн.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
70 % биелэлттэй явж байгаа	Сумын хэмжээн дахь түүх соёлын дурсгалт газар, байгалийн өвөрмөц тогтоц, иргэдийн гар дээр байгаа эд өлгийн зүйлсийг баримтжуулах ажил хийсэн.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Видео бичлэг зургаар баталгаажуулсан байсан. Үүнийг нь үзэж амжаагүй.	Сумын орлогч дарга, сурагч, багш нар нийлсэн 8 хүний бүрэлдэхүүнтэй хийсэн.	Нийт 23 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -9 Дунд - 3 Муу - 3

Хавсралт : Ажил гүйцэтгэх гэрээ 1 хуудас материал

2.5 Багийн дарга нарыг унаажуулах.

Энэхүү төсөл нь 3,7 сая төгрөгний төсөвтэй ажил. Уг ажлыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан. Ажлыг 5-р багийн иргэн Ч.Гантөмөр гэрээлэн гүйцэтгэсэн байна. Багийн засаг дарга нарт Мустанг 150 маркын 5 ш мотоцикл нийлүүлсэн.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
100 % биелэлттэй хүлээн авсан акт нь байхгүй.	Багийн засаг дарга нарт Мустанг 150 маркын 5 ш мотоцикл нийлүүлсэн. Одоо ашиглаж байгаа	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. 4 сар гаруй ашиглаж байна. Ямар нэгэн эвдрэл гараагүй. Очиж үзэж чадаагүй.	Иргэдийн хяналт тавиагүй.	Нийт 23 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -13 Дунд - 3 Муу - 2

Хавсралт : үнийн санал авах урилга, Техникийн тодохойлолт, Ажил гүйцэтгэх гэрээ 4 хуудас материал

Дүгнэлт

Судалгааны дүгнэлээс харахад

1. Та сумын 2013 оны орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын төлөвлөлтөнд саналаа өгч оролцсон уу гэсэн асуултанд
Тийм -12 Үгүй - 10
2. Хэрэв та төлөвлөлтөнд саналаа өгч оролцсон бол таны санал төлөвлөгөөнд тусгагдаж чадсаны гэсэн асуултанд
Тийм – 9 Үгүй - 3
3. Орон нутгийн хөгжлийн сангаар танай суманд ямар ямар ажлууд хийгдэхээр төлөвлөснөөс одоогоор ямар ямар ажлууд хийгдсэн талаар та мэдэж байна уу гэсэн асуултанд
Тийм – 11 Үгүй – 10

4. Танай суманд тендер зохион байгуулалт хэр зэрэг шударга явагддаг вэ гэсэн асуултанд
Шударга явагддаг – 7
Шударга бус явагддаг – 10
Мэдэхгүй – 6
5. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын төлөвлөлт, шалгаруулалт, хэрэгжилтэнд хяналт тавих эрхтэй гэдгээ та мэдэхүү гэсэн асуултанд
Тийм – 14 Үгүй -4

Судалгаанаас үзэхэд уг суманд хийгдэж байгаа худалдан авах ажиллагаа нь нээлттэй ил тод биш, тендерийн урилга зарыг олон нийтэд хүргэдэггүй, иргэдэд хийсэн ажлынхаа талаар тайлагнадаггүй байна.

Ололттой тал :

- Орон нутгийн зам засах ажлыг нутгийн иргэдийн оролцоотой гүйцэтгэсэн нь олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны эхлэл болж байна гэж үзэж байна.

Хүндрэл бэрхшээл :

- Үнэлгээний хороонд орж ажиллаж байгаа хүмүүсийн мэдлэг маш муу
- Иргэдийн хувьд худалдан авах ажиллагааны талаар ойлголт хангалтгүй
- Тендерийн урилга олон нийтэд түгээх боломж хомс

Анхаарах зүйлс :

- Худалдан авах ажиллагааны талаарх сургалт суртачилгааг олон нийтэд хийж зөв ойлголт өгөх.
- Үнэлгээний хорооны гишүүдийн мэдлэгийг нэмэгдүүлэх.
- Хийсэн ажил, шалгарсан тендерүүдийн явцын талаар иргэдэд мэдээлэл өгч байх.
- Тухайн худалдан авах ажиллагааны талаарх материалууд дутуу байгаа нь бичиг баримт бүрдүүлэлт, архивлах тал дээр анхаарах хэрэгтэйг харуулж байна.
- Байгуулсан гэрээнүүд нь гэрээний наад захын шаардлага хангахгүй байна. Үүнд талуудын үүрэг хариуцлага тодорхой бус, санхүүжилтийн хуваарь байхгүй, гэрээ зөрчсөн үед авах арга хэмжээний талаар тусгаагүй байна. Иймд гэрээ байгуулахдаа эдгээр зүйл заалтыг нарийн тусгаж ажиллах хэрэгтэй.
- Олон нийтийн оролцоотой худалдан авалт зохион байгуулж болох ажлуудыг шүүд худалдан авалтийн аргаар бус олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаагаар зохион байгуулах.
- Тендер шалгаруулалтын архивын бүрдэлтийг бүрэн гүйцэт хөтлөх.
- Ижил төстэй ажлуудыг үнийн дүнг багасах зорилгоор хэсэглэн худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй байх

2 Улаангом сум

2.1 Автобусны маршрут тогтоож 5 газар зогсоол барьж тохижуулах.

Энэхүү ажил нь 57 сая төгрөгний төсөвтэй . Уг ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан. Тендерт “Гурван нуур” ХХК, “Их барилга” ХХК , “Дэглий Цагаан” ХХК оролцож “Дэглий Цагаан” ХХК шалгарчээ.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
100 % биелэлттэй хүлээлгэн өгсөн. Акт нь байгаа	5 газар автобусны зогсоол барьсан	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзэхэд 2 зогсоолын циллодон хаалтыг хага цохисон байсныг төмрөөр дахин битүүлж хаасан байна. Анхнаасаа нимгэн циллодон материалаар хийсэн байна.	Явцын дунд хяналт үнэлгээг хийж байсан. Явцын тайланг нь үзэж байсан. Иргэдийн хувьд хяналт хийгээгүй.	Нийт 27 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -4 Дунд – 17 Муу - 6

Хавсралт : Урилга, хурлын протокол, хүлээн авсан акт б хуудас материал





2.2 Улаангом сумын төв гудамжны ногоон байгууламж хийж гүйцэтгэх.

Энэхүү ажил нь 75 сая төгрөгний төсөвтэй . Уг ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан. 2 удаа зарласан боловч оролцогч ирээгүй. 3 дахь удаагаа зарлаж “Суварга булан” ХХК материалаа ирүүлж тендерийг хүлээн авч шалгаруулсан..

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
100 % биелэлттэй хүлээлгэн өгсөн. Акт нь байгаа	Улаангом сумын төв замын дагуух ногоон байгууламжийг зүлэгжүүлж, суулгац шинээр тариж, хашлага цэцгийн мандал хийсэн.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзсэн.	Явцын дунд хяналт үнэлгээг хийж байсан. Явцын тайланг нь үзэж байсан. Иргэдийн нүдэн дээр хийсэн ажил учир хяналт тавьж байсан гэж болно..	Нийт 27 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -20 Дунд – 7

Хавсралт : Урилга, хурлын протокол, гэрээ, хүлээн авах комисс байгуулсан тогтоол 4 хуудас материал



2.3 Улаангом хотын хог тээвэрлэлтийн авто машины парк шинэчлэл.

Энэхүү ажил нь 78,9 сая төгрөгний төсөвтэй . Уг ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан. Тендерт “Цэнгүүн Чингүүн” ХХК, “Хүдэнгийн уурхай” ХХК, “Шинэ Эрин” ХХК, “Наран Болор” ХХК, “Дэвшил Увс” ХХК оролцож “Цэнгүүн Чингүүн” ХХК шалгарсан.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
100 % биелэлттэй хүлээлгэн өгсөн. Акт гэрээ нь улсын дугаар авахад хэрэгтэй гээд аваад явсан	110 ш хогийн бункер, 100 км-т 5-8 л түлш зарцуулдаг битүү тээвэрлэлттэй хогний машин	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзсэн.	Шүүд нийлүүлэгдсэн болхоор хүлээж авхаас өөр хяналт хийгдээгүй.	Нийт 27 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -20 Дунд – 3

Хавсралт : Урилга, хурлын протокол, зэрэг 5 хуудас материал

2.4 Улаангом сумын 2-р цэцэрлэгээс хар зам хүртэлх замыг хайргажуулах, засах

Энэхүү ажил нь 9,9 сая төгрөгний төсөвтэй . Уг ажлыг шууд гэрээ байгуулсан. Ажлыг “Баруун загвар” ХХК хийж гүйцэтгэсэн.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
100 % биелэлттэй хүлээлгэн өгсөн. Акт гэрээ нь төрийн сан дээр байгаа	340 м хайрган хучилттай зам тавьж, цэцэрлэгийн гадна авто зогсоол хийсэн.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзсэн.	Явцын дунд хяналт үнэлгээ хийж байсан.	Нийт 27 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -15 Дунд – 4

Хавсралт : Гэрээ 1 хуудас материал



2.5 Улаангом сумын 1-р цэцэрлэгийн гадна хашаа, тоглоомын талбай тохижуулах

Энэхүү ажил нь 20 сая төгрөгний төсөвтэй . Тендер шалгаруулалтанд 1 компаний материал ирж уг ажлыг “Тавалжин Арвин” ХХК хийж гүйцэтгэсэн.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
100 % биелэлттэй хүлээлгэн өгсөн. Акт нь байгаа	Цэцэрлэгийн эрэгэн тойрон 58x123 м квадрат хашаа барьж, тоглоомын талбай хийж гүйцэтгэсэн.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзсэн.	1-р цэцэрлэгийнхэн өөрсдөө хяналт тавьж ажилласан.	Нийт 27 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -20

Хавсралт : Гэрээ, хурлын протокол тайлан зэрэг 6 хуудас материал



2.6 Улаангом сумын иргэний танхим тохижуулах

Энэхүү ажил нь 10 сая төгрөгний төсөвтэй . Уг ажлыг шууд гэрээ байгуулсан. “Шинэ Эрин” ХХК хийж гүйцэтгэсэн.

Ажлын гүйцэтгэл	Хийсэн ажил	Ажлын чанар	Иргэдийн хяналт үнэлгээ	Иргэдийн сэтгэл ханамж
100 % биелэлттэй хүлээлгэн өгсөн. Акт нь байгаа	Иргэний танхимын ширээ сандал, тоног төхөөрөмж нийлүүлсэн.	Чанарын хувьд сайн гэж үзэж байгаа. Очиж үзсэн.	Иргэдийн зүгээс хяналт байхгүй.	Нийт 27 хүн судалгаанд хамрагдсанаас Сайн -15 Дунд – 6

Хавсралт : Гэрээ, акт, үндэслэл зэрэг 4 хуудас материал



Дүгнэлт

Судалгааны дүгнэлээс харахад

6. Та сумын 2013 оны орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын төлөвлөлтөнд саналаа өгч оролцсон уу гэсэн асуултанд
Тийм -20 Үгүй - 7
7. Хэрэв та төлөвлөлтөнд саналаа өгч оролцсон бол таны санал төлөвлөгөөнд тусгагдаж чадсануу гэсэн асуултанд
Тийм – 10 Үгүй - 10
8. Орон нутгийн хөгжлийн сангаар танай суманд ямар ямар ажлууд хийгдэхээр төлөвлөснөөс одоогоор ямар ямар ажлууд хийгдсэн талаар та мэдэж байна уу гэсэн асуултанд
Тийм – 8 Үгүй – 19
9. Танай суманд тендер зохион байгуулалт хэр зэрэг шударга явагддаг вэ гэсэн асуултанд
Шударга явагддаг – 6
Шударга бус явагддаг – 21
10. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажлын төлөвлөлт, шалгаруулалт, хэрэгжилтэнд хяналт тавих эрхтэй гэдгээ та мэдэхүү гэсэн асуултанд
Тийм – 27 Үгүй -0

Судалгаанаас үзэхэд уг суманд хийгдэж байгаа худалдан авах ажиллагаа нь нээлтэй ил тод биш, иргэдэд хийсэн ажлынхаа талаар тайлагнадаггүй байна.

Ололттой тал :

- Хийсэн ажил бүрт явцын хяналт тавиж ажилласан ба, нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн хийсэн ажлууд нь чанартай сайн болсон байна.

Хүндрэл бэрхшээл :

- Зарим зарласан тендерт үнийн санал ирэхгүй байна.
- Хийж гүйцэтгээд дууссаны дараа иргэд эвдэж гэмтээж байна.

Анхаарах зүйлс :

- Худалдан авах ажиллагааны талаарх сургалт суртачилгааг олон нийтэд хийж зөв ойлголт өгөх.
- Хийсэн ажил, шалгарсан тендерүүдийн явцын талаар иргэдэд мэдээлэл өгч байх.
- Тухайн худалдан авах ажиллагааны талаарх материалууд дутуу байгаа нь бичиг баримт бүрдүүлэлт, архивлах тал дээр анхаарах хэрэгтэйг харуулж байна.
- Байгуулсан гэрээнүүд нь гэрээний наад захын шаардлага хангахгүй байна. Үүнд талуудын үүрэг хариуцлага тодорхой бус, санхүүжилтийн хуваарь байхгүй, гэрээ зөрчсөн үед авах арга хэмжээний талаар тусгаагүй байна. Иймд гэрээ байгуулахдаа эдгээр зүйл заалтыг нарийн тусгаж ажиллах хэрэгтэй.

- Олон нийтийн оролцоотой худалдан авалт зохион байгуулж болох ажлуудыг шууд худалдан авалтийн аргаар бус олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаагаар зохион байгуулах.
- Тендер шалгаруулалтын архивын бүрдэлтийг бүрэн гүйцэт хөтлөх.

Тайлан бичсэн

/Р.Итгэл/